



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/436

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Прокурорын байгууллагын ажилтаны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, үүрэгт ажилдаа хууль тогтоомж, заавар журмыг хэрэгжүүлэн, Улсын Ерөнхий прокуророос дэвшүүлсэн бодлого, зорилтуудыг нэгжид ханган биелүүлэх, хяналтын ажлын чанар, үр дүнг сайжруулахад хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг/ ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн
А/436 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

| № | Овог нэр | Эрхэлж буй ажил, албан тушаал | Мөнгөн дүн |
|-----|----------------|---|------------|
| 1. | Д.Батболд | Булган сум дахь Сум дундын прокурорын жижүүр | 30000 |
| 2. | З.Алтансолонго | Прокурорын газрын хяналтын прокурор | 30000 |
| 3. | Э.Ууганзаяа | Аймгийн Прокурорын газрын хэрэг бүртгэх, хяналтын прокурор | 30000 |
| Дүн | | | 90000 |

-oOo-